

## CAWI - Computer Assisted Web Interview

Интернэтэд суурилсан онлайнаар мэдээлэл цуглуулах арга



Орчин үед интернэтийн нэвтрэлт хурдацтай тархаж, ухаалаг гар утасны хэрэглээ нэмэгдсэнтэй холбоотойгоор **CAWI (Computer Assisted Web Interview)** буюу интернэтэд (вэб-д) суурилсан онлайнаар мэдээлэл цуглуулах аргаар судалгааг авах боломж бүрдсэн юм. Бид онлайн судалгааны вэб сайтад тулгуурлан судалгааны асуулгыг боловсруулан судалгаанд оролцогчийн и-мэйл хаяг, фэйсбүүк хаяг руу линк явуулах, мөн өөрийн вэб сайтад судалгааны асуулга байршуулан мэдээлэл цуглуулалтыг богино хугацаанд, бага зардалаар хийх боломжтой.

Бид онлайн судалгааны сайтуудын техникийн боломж, ашиглалтын нөхцөл байдлыг сайтар судлан үзсний үндсэн дээр судалгааны шилдэг сайт болох Survey Gizmo сайтай хамтран ажиллаж байна.

Онлайн судалгааны давуу талууд:

- Мэдээлэл цуглуулахад хялбар, хурдан, зардал бага
- Интернэтэд холбогдох боломжтой аль ч газраас судалгаанд оролцоно
- Компьютер, таблет, ухаалаг гар утас зэрэг интернэтэд холбогдох боломжтой бүх төхөөрөмжөөр судалгаанд оролцоно
- Зорилтот хэрэглэгчдийг судалгаанд хамруулах боломжтой
- Судалгааны мэдээлэл цуглуулалтын процессийг бүрэн хянах боломжтой
- Зураг, дуу, бичлэг үзүүлж интерактив байдлаар судалгааг явуулах боломжтой
- Логик, асуулгын шилжилт хийх боломжтой